



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/33

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Захиргааны ерөхний хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн 2025 оны эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалжийн тендерийн зарим багцуудын гэрээний тоо ширхэг дууссан тул он дуустал шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалжийг нэмэлтээр тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Аззаяа (Сургалт, хөгжил, бодлого, төлөвлөлт гүйцэтгэлийн алба)

Нарийн бичиг :Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Гишүүд:Ц.Лувсандамдин (Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга)

Ц.Мөнгөнтуяа (Эм зүйн албаны дарга)

Ц.Соёлбадрах (Иргэний төлөөлөл)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Аззаяа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН